



# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

**Аудитын код:** ГСАТАГ-2019/39/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойр  
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 7054-3151

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 7054-3179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Аудитор: Д.Оюунбат

Утас: 7054-3179

Цахим хаяг: Oyuna200702@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам



## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал	11-13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14-23



## 1 Аудитын гэрчилгээ

---



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч Н.Даваахүүд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.15-наас 2019.02.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Саруул баян уул- аудит” ХХК-ийн аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Саруул баян уул-аудит” ХХК-д 2019.02.11-ний өдрийн 01/39 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн нь хуулийн хугацаанаас 9 хоног хоцроосон байна.



### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Хөдөө аж ахуйн үйл ажиллагааг үр ашигтай эрхлэн явуулахад дэмжих, удирдан зохицуулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Хөдөө аж ахуйн үйл ажиллагааг үр ашигтай эрхлэн явуулахад дэмжих, удирдан зохицуулах төрийн байгууллагын үйл ажиллагаа” гэж тодорхойлжээ.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай
- Хүнсний тухай

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн "ACOLOUS" програм хангамж ашигладаг байна.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "бага" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт "Үр нөлөөтэй" гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг



баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Нийт зардал”-ын 1 хувиар сонгов.

“Нийт зардал”-ыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцоход үлдэгдлийг төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд бүрэн зарцуулагддаггүй, нийт хөрөнгийн дүн өндөр байгаа тул нийт зардлыг суурь болгон сонгох нь зохимжтой гэж үзэв

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2018 оны нийт зардал 684,908.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 6,849.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь өмнөх аудитаар зөрчилгүй дүгнэлт авч байсантай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 10 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.





Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(мянган төгрөг)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	914.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	468,6	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Аудитын явцад залруулсан	2	49,031.9	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	6	50,415.2	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант хугацаанд 102.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 13 дугаар заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Дотоод журмын шаардлага хангаагүй, анхан шатны баримтын иж бүрдэлгүй 366.2 мянган төгрөгийн цалинтай чөлөө олгосон байна.

Энэ нь “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 2.8.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Нийгмийн даатгалын тайланд 776.7 мянган төгрөгийн ажилчдын цалинг дутуу тайлагнасан

Энэ нь “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалтыг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Дутуу тайлагнасан 776.7 мянган төгрөгийн цалинг нөхөн тайлагнах зөвлөмж өгөв.

#### **2.8.1.4 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Үнэ төлбөргүй хүлээн авсан 48,934.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу бүртгэсэн.

Энэ нь “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

#### **2.8.1.5 Зардлын данстай холбоотой асуудал**

Нийгмийн даатгалын шимтгэлийн 97.7 мянган төгрөгийн хөнгөлөлтийг бүртгээгүй.

Энэ нь “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

#### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 153,751.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсөвт зардлын гүйцэтгэл 153,750.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа бөгөөд нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн санхүүжилт 153,751.1 мянга, нэмэлт санхүүжилт 222,929.1 мянга, үйл ажиллагааны орлого 277.8 мянга, ХХААХҮЯ-аас үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 48,934,2 мянган төгрөгийн автомашин, сум хөгжүүлэх сангийн програм хүлээн авсан ба бараа материалд 328,723.5 мянган төгрөгийн ногооны үр вакцин, эм бэлдмэлийг бүртгэлд тусгаж, нийт 376,535.5 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.



Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн санхүүжилт 153,751.1 мянга, нэмэлт санхүүжилт 222,929.1 мянга, үйл ажиллагааны орлого 277.8 мянга, нийт 752,615.7 мянган төгрөг бүртгэсэн байна.

Оны эхэнд 198.0 мянган төгрөгийн авлагатай, өглөггүй байсан бөгөөд тайлант онд 1,773.0 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан байна. Өглөг нэмэгдсэн нь төсөв хасагдаж батлагдсан ба үндэслэлгүй цалинтай чөлөө олгодог, өндөр насны тэтгэвэрт гарсан хүнийг өндөр шатлалаар цалинжуулсан зэрэг нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнгээр, дахин үнэлгээний нэмэгдэл данс 9,377.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, үнэлгээний бууралтаар 19,005.3 мянган төгрөгийг тайлант жилийн зардлаар бүртгэсэн байна.

Мөн байгууллагын эзэмшилд байгаа газар 170,081,3 мянган төгрөгөөр үнэлэгдэж, биет бус хөрөнгийн дансанд бүртгэж, засгийн газрын сангаа нэмэгдүүлсэн байна.

Бараа материалын данс нь 118,255.6 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 10,324.5 мянга, ХХААХҮЯ-аас 328,033.5 мянга, нас дэвшилтээр 689.0 мянга, нийт 339,047.9 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан ба 268,643.3 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж, нас дэвшилтээр 873.0 мянга, газрын даргын 2018.02.26-ны А/04 дүгээр тушаалаар 477.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, нийт 269,516.3 мянган төгрөг зарцуулж, 187,787.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар Мал эмнэлэгийн ерөнхий газраас 208,569.1 мянга, аймгийн Засаг даргын нөөц сангаас шүлхийний зардалд 11,128.7 мянга, ХХААХҮЯ-аас 3,231.2 мянга, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатороос 1,039.5 мянга, нийт 222,929.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллийн 3 буюу 2.0 хувь нь хугацаа болоогүй, 24 буюу 16.4 хувь нь хугацаа хоцорсон мэдээлэл байна. Цаашид шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулан ажиллах нь зүйтэй.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/27 дугаартай албан тоотоор мэдээлсэн ба биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.



### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.



### 3.1 ЗАРДЛЫН ТАЛААР

#### Илрүүлэлт

Ажиллагсдад ХХОАТ-ын хөнгөлөлтийг 29.1 мянган төгрөгөөр дутуу, 108.9 мянган төгрөгөөр илүү, нийт 138.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцсон.

Энэ нь “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэлд нийцээгүй бөгөөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.1 дэх заалтыг зөрчсөн байна.

#### Зөвлөмж

ХХОАТ-ыг хуулийн дагуу үнэн зөв тооцож тайлагнаж байх

#### Хариуцах ажилтан

Дарга  
Нягтлан бодогч

Н.Даваахүү  
Н.Гандирмаа

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

#### Эрсдэл

Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс ажиллагсдад эрсдэл үүсэх



### 3.2 БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР

#### Илрүүлэлт

Нийгмийн даатгалын хэлтэст ажилчдын цалинг 776.7 мянган төгрөгрөөр дутуу тайлагнасан.

Энэ нь “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэлд нийцээгүй бөгөөд НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

#### Зөвлөмж

НДШ-ийн тайланг тухай бүр үнэн зөв тооцож тайлагнаж байх

#### Хариуцах ажилтан

Дарга  
Нягтлан бодогч

Н.Даваахүү  
...Н.Гандирмаа

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

#### Эрсдэл

Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс удирдлага, нягтлан бодогч нар эрсдэл үүсэх эрсдэлтэй



## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

СТ-1А

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	121,303,928.09	187,985,227.50
2	АВЛАГА	198,364.31	198,087.90
3	Ажиллагсадтай холбогдсон авлага	276.41	
4	Бусад авлага	198,087.90	198,087.90
5	Байгууллагаас авах авлага	198,087.90	198,087.90
6	УРЬДЧИЛГАА	2,850,000.00	-
7	Урьдчилж гарсан зардал	2,850,000.00	-
8	БАРАА МАТЕРИАЛ	118,255,563.78	187,787,139.60
9	Түүхий эд материал	85,593,876.17	154,431,878.29
10	Тусгай зориулалттай материал	2,350,000.00	2,350,000.00
11	Эм боох материал	83,243,876.17	152,081,878.29
12	Хангамжийн материал	31,021,687.61	32,146,261.31
13	Бичиг хэргийн материал	735,164.00	906,114.40
14	Аж ахуйн материал	11,497,552.50	14,220,822.50
15	Түлш шатах тослох материал	11,520.00	-
16	Бусад хангамжийн материал	18,777,451.11	17,019,324.41
17	Мал, амьтад	1,640,000.00	1,209,000.00
18	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	302,013,373.28	487,512,973.37
19	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	302,013,373.28	487,512,973.37
20	Биет хөрөнгө	301,940,039.80	316,013,317.85
21	Барилга, байгууламж	294,727,853.00	254,307,947.00
22	Хуримтлагдсан элэгдэл	(70,518,783.53)	(38,629,026.84)
23	Авто тээврийн хэрэгсэл	183,940,909.67	231,475,080.67
24	Хуримтлагдсан элэгдэл	(132,651,117.58)	(156,785,630.88)
25	Машин, тоног төхөөрөмж	147,715,191.98	147,715,191.98
26	Хуримтлагдсан элэгдэл	(132,158,026.43)	(139,386,089.23)
27	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,406,170.00	17,406,170.00
28	Хуримтлагдсан элэгдэл	(6,522,157.31)	(8,125,517.79)
29	Бусад үндсэн хөрөнгө	-	30,791,940.00
30	Хуримтлагдсан элэгдэл	-	(22,756,747.06)
31	Биет бус хөрөнгө	73,333.48	171,499,655.52
32	Програм хангамж	792,500.00	2,192,500.00
33	Хасагдуулга	(719,166.52)	(774,166.48)
34	Бусад биет бус хөрөнгө	-	170,081,322.00
35	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	423,317,301.37	675,498,200.87
36	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	1,773,086.03





“Хүнс хөдөө аж ауйн газар”-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

37	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	1,773,086.03
38	Өглөг	(0.00)	1,773,086.03
39	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	1,773,086.03
40	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	423,317,301.37	673,725,114.84
41	Засгийн газрын хувь оролцоо	423,317,301.37	673,725,114.84
42	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	325,415,356.25	495,496,678.25
43	Өмч: -Төрийн өмч	325,415,356.25	495,496,678.25
44	Хуримтлагдсан үр дүн	88,165,839.35	159,114,980.10
45	Өмнөх үеийн үр дүн	88,165,839.35	88,165,839.35
46	Тайлант үеийн үр дүн	-	70,949,140.75
47	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,736,105.77	19,113,456.49
48	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	423,317,301.37	675,498,200.87



СТ-2А

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	479,271,398.01	755,817,383.73
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	285,653,240.86	377,637,158.73
3	Нийтлэг татварын бус орлого	285,653,240.86	377,344,158.73
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	285,653,240.86	377,344,158.73
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,162,750.00	277,840.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	284,490,490.86	377,066,318.73
7	Зээлийн орлого	-	293,000.00
8	Бараа материал худалдсаны олз	-	293,000.00
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	144,120,257.15	155,251,100.00
10	Улсын төвлөрсөн төсвөөс	141,120,257.15	155,251,100.00
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,477,400.00	155,251,100.00
12	Хөрөнгийн санхүүжилт	29,642,857.15	-
13	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	49,497,900.00	222,929,125.00
14	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,000,000.00	-
15	Төсвийн захирагчдаас	3,000,000.00	-
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	555,294,543.09	684,868,242.98
17	УРСГАЛ ЗАРДАЛ	555,294,543.09	677,584,542.98
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,169,543.09	676,052,082.98
19	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	88,835,245.00	122,202,917.00
20	Цалин	88,835,245.00	122,202,917.00
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,620,312.83	15,008,486.62
22	Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,572,579.38	10,333,765.80
23	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	748,685.45	1,242,000.82
24	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	656,122.00	1,021,733.00
25	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	149,357.00	219,208.00
26	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,493,569.00	2,191,779.00



“Хүнс хөдөө аж ауйн газар”-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

27	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,033,185.00	7,363,112.52
28	Гэрэл цахилгааны зардал	672,593.00	1,037,833.00
29	Түлш, халаалтын зардал	4,032,682.00	6,163,120.52
30	Цэвэр, бохир усны зардал	327,910.00	162,159.00
31	Хангамж, бараа материалын зардал	5,255,783.80	8,065,303.08
32	Бичиг хэргийн материал	607,436.80	1,278,569.60
33	Тээвэр, шатахууны зардал	1,864,291.00	3,953,560.00
34	Шуудан холбоо интернетийн төлбөр	878,276.00	1,339,843.48
35	Хог хаягдал устгах, цэвэрлэх	56,000.00	96,000.00
36	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,813,780.00	920,330.00
37	Бараа материал актасны зардал	36,000.00	477,000.00
38	Нормативт зардал	355,972,590.38	255,155,356.13
39	Эм	355,972,590.38	255,155,356.13
40	Эд хогшил, урсгал засварын зардал	970,100.00	349,320.00
41	Урсгал засвар	970,100.00	349,320.00
42	Томилолт, зочны зардал	1,621,500.00	1,751,450.00
43	Дотоод томилолтын зардал	1,621,500.00	1,751,450.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	46,015,262.00	16,246,684.00
45	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,117,000.00	14,624,640.00
46	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	480,000.00
47	Даатгалын үйлчилгээний төлбөр	494,390.00	483,900.00
48	Тээврийн хэрэгслийн татвар	222,700.00	350,000.00
49	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	130,182.00
50	Газрын төлбөр	82,172.00	177,962.00
51	Бараа үйлчилгээний бусад зардал	40,845,564.08	249,909,453.63
52	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	207,016,210.00
53	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	55,000.00	-
54	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,790,564.08	42,893,243.63
55	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,125,000.00	1,532,460.00
56	Бусад урсгал шилжүүлэг	1,125,000.00	1,499,200.00
57	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,125,000.00	1,499,200.00



“Хүнс хөдөө аж ауйн газар”-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

58	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	33,260.00
59	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,260.00
60	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>7,283,700.00</b>
61	Дотоод эх үүсвэрээр	-	7,283,700.00
62	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	7,283,700.00
63	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(76,023,145.08)	70,949,140.75
64	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
65	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>(76,023,145.08)</b>	<b>70,949,140.75</b>



4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөг/

№	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	340,244,350.00	378,458,065.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,566,670.00	277,840.00
3	Нийтлэг татварын бус орлого	1,566,670.00	277,840.00
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,566,670.00	277,840.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,566,670.00	277,840.00
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	338,677,680.00	378,180,225.00
7	Улсын төвлөрсөн төсвөөс	163,555,800.00	155,251,100.00
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	163,555,800.00	155,251,100.00
9	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	170,121,880.00	222,929,125.00
10	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,000,000.00	-
11	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт	5,000,000.00	-
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	339,384,350.00	378,458,065.00
13	УРСГАЛ ЗАРДАЛ	339,384,350.00	378,458,065.00
14	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,202,259.83	376,925,605.00
15	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	120,160,677.83	120,839,500.00
16	Үндсэн цалин	114,339,941.83	100,601,256.00
17	Нэмэгдэл	-	13,408,148.00
18	Унаа хоолны хөнгөлөлт	5,820,736.00	6,830,096.00
19	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	13,380,000.00	14,500,800.00
20	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,891,200.00	9,020,185.00
21	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,073,300.00	1,855,415.00
22	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	936,700.00	966,700.00
23	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	137,000.00	241,700.00
24	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,341,800.00	2,416,800.00
25	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	8,694,404.00	7,363,112.52
26	Гэрэл цахилгааны зардал	915,568.00	1,037,833.00
27	Түлш, халаалтын зардал	6,980,566.00	6,163,120.52
28	Цэвэр, бохир усны зардал	798,270.00	162,159.00
29	Хангамж, бараа материалын зардал	4,742,611.00	5,334,858.48
30	Бичиг хэрэг	609,200.00	719,942.00
31	Тээвэр, шатахуун	2,479,400.00	3,120,205.00
32	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,321,111.00	1,345,311.48
33	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	56,000.00	96,000.00
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	276,900.00	53,400.00
35	Нормативт зардал	692,210.00	1,484,525.00
36	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	624,570.00	1,484,525.00
37	Нормын хувцас, зөөлөн эдлэл	67,640.00	-
38	Эд хогшил, урсгал засварын зардал	1,635,200.00	924,000.00
39	Багаж техник хэрэгсэл	-	50,000.00



“Хүнс хөдөө аж ауйн газар”-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

40	Урсгал засвар	1,635,200.00	874,000.00
41	Томилолт, зочны зардал	2,327,250.00	1,651,450.00
42	Дотоод албан томилолт	2,327,250.00	1,651,450.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174,365,142.00	89,101,129.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	173,466,880.00	87,736,235.00
45	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000.00
46	Даатгалын үйлчилгээ	494,390.00	506,750.00
47	Тээврийн хэрэгслийн татвар	222,700.00	350,000.00
48	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	130,182.00
49	Газрын төлбөр	82,172.00	177,962.00
50	Бараа үйлчилгээний бусад зардал	5,204,765.00	135,726,230.00
51	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	135,726,230.00
52	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	204,765.00	-
53	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,182,090.17	1,532,460.00
54	Бусад урсгал шилжүүлэг	5,700,000.00	1,499,200.00
55	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,499,200.00
56	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,200,000.00	-
57	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,482,090.17	33,260.00
58	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,482,090.17	33,260.00
59	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	860,000.00	-
60	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
61	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	860,000.00	-
62	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	860,000.00	-
63	Дотоод эх үүсвэрээр	860,000.00	-
64	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	860,000.00	-
65	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(860,000.00)	-
66	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
67	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
68	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	-
69	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



СТ-4А

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	ДАНС	511	51300	51210+51220	
2	2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	325415356.3	9736105.77	168975527.8	504126989.8
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	325415356.3	9736105.77	168975527.8	504126989.8
5	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	-76023145.08	76023145.08
6	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	325415356.3	9736105.77	88165839.35	423317301.4
7	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	325415356.3	9736105.77	88165839.35	423317301.4
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	325415356.3	9736105.77	88165839.35	423317301.4
9	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0	9377350.72	0	9377350.72
10	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	170081322	0	70949140.75	241030462.8
11	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	495496678.3	19113456.49	159114980.1	673725114.8



#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,971,815.00	378,302,125.00	(177,330,310.00)
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	200,971,815.00	378,302,125.00	(177,330,310.00)
4	Бараа, үйлчилгээний зардал	199,471,815.00	376,802,925.00	(177,331,110.00)
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,839,500.00	120,839,500.00	-
6	Үндсэн цалин	100,691,200.00	100,601,256.00	89,944.00
7	Нэмэгдэл	14,019,800.00	13,408,148.00	611,652.00
8	Унаа, болон бусад нөхөн олговор	6,128,500.00	6,830,096.00	(701,596.00)
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,500,800.00	14,500,800.00	-
10	Тэтгэврийн даатгал	9,667,200.00	9,020,185.00	647,015.00
11	Тэтгэмжийн даатгал	1,208,400.00	1,855,415.00	(647,015.00)
12	ҮОМШӨ ний даатгал	966,700.00	966,700.00	-
13	Ажилгүйдлийн даатгал	241,700.00	241,700.00	-
14	Эрүүл мэндийн даатгал	2,416,800.00	2,416,800.00	-
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,196,600.00	7,363,112.52	833,487.48
16	Гэрэл цахилгаан	1,251,600.00	1,037,833.00	213,767.00
17	Түлш, халаалт	6,461,300.00	6,163,120.52	298,179.48
18	Цэвэр, бохир ус	483,700.00	162,159.00	321,541.00
19	Хангамж, бараа материалын зардал	5,779,100.00	5,334,858.48	444,241.52
20	Бичиг хэрэг	698,500.00	719,942.00	(21,442.00)
21	Тээвэр (шатахуун)	3,509,500.00	3,120,205.00	389,295.00
22	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,057,700.00	1,345,311.48	(287,611.48)
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00	-
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	417,400.00	53,400.00	364,000.00
25	Нормативт зардал	1,485,000.00	1,484,525.00	475.00
26	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,485,000.00	1,484,525.00	475.00
27	Эд хогшил худалдан авах	934,800.00	924,000.00	10,800.00
28	Багаж, техник, хэрэгсэл	-	50,000.00	(50,000.00)
29	Урсгал засвар	934,800.00	874,000.00	60,800.00
30	Томилолт, зочны зардал	1,652,200.00	1,651,450.00	750.00
31	Дотоод албан томилолт	1,652,200.00	1,651,450.00	750.00
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	33,995,875.00	89,101,129.00	(55,105,254.00)
33	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,617,575.00	87,736,235.00	(55,118,660.00)
34	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	200,000.00	200,000.00	-





“Хүнс хөдөө аж ауйн газар”-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35	Даатгалын үйлчилгээ	506,700.00	506,750.00	(50.00)
36	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	350,000.00	-
37	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	130,182.00	12,818.00
38	Газрын төлбөр	178,600.00	177,962.00	638.00
39	Бараа үйлчилгээний бусад зардал	12,087,940.00	135,603,550.00	(123,515,610.00)
40	Бараа үйлчилгээний бусад зардал	11,971,140.00	135,603,550.00	(123,632,410.00)
41	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	116,800.00	-	116,800.00
42	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,499,200.00	800.00
43	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,499,200.00	800.00
44	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,499,200.00	800.00
45	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	155,251,100.00	378,425,605.00	(223,174,505.00)
46	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	153,751,100.00	378,147,765.00	(224,396,665.00)
47	Улсын төсвөөс санхүүжих	153,751,100.00	155,251,100.00	(1,500,000.00)
48	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	222,896,665.00	(222,896,665.00)
49	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	277,840.00	1,222,160.00
50	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	277,840.00	1,222,160.00
49	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
50	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-